

## **Айлд мал маллаж буй хүүхдүүдийн сургууль завсардалтад нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ**

**МУИС-ийн ЭЗС-ийн Хүн ам зүйн 4 дүгээр ангийн оюутан Д.Анхзаяа  
Удирдсан багш: МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ-ийн захирал А.Солонго**

*Манай оронд 1990-ээд оны эхээр сургууль завсардалт урьд байгаагүй түвшинд хүртэл нэмэгдэж, хүн амын нэлээд хэсэг нь ядуурч, сургууль завсардсан хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь бодит үзэгдэл болсоор 10 гару ѵжилж болж байна. Сургууль завсардалт нь хүүхдийн сурах, хөгжих, улмаар нийгмийн бүтээлч иргэн болж төлөвшийн садаа учруулж, хүүхдийн үндсэн эрхийг зорчиж буй үзэгдэл юм.*

Энэхүү судалгааны зорилго нь хөдөөд айлд мал маллаж, гэрийн ажил хийж буй 7-15 наасны хүүх дүүдийн сургууль завсардалтын байдлыг гүнзгийрүүлэн судалж, сургууль завсардалтын шалтгааныг нь хүн ам зүй, нийгэм-өрх, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй хамааруулж, уялдаа холбоог тодорхойлох явдал байв. Суда лгаанд “Гэрийн үйлчлэгч хүүхдийн суурь судалгаа”-ны “Айлд мал малладаг хүүхдийн судалгаа” -ны мэдээллийг ашиглан шалтгааны загвар болон статистикийн хоёр ба олон хүчин зүйлийн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг үндэслэн зөвлөмж гаргасан.

*Мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтанд тухайн хүүхдийн анх ажил хийж эхэлсэн нас, эхийн боловсрол, ажил эрхлэлт, хүчирхийлэлд өртөсөн байдал, өрхийн үндсэн хөрөнгө, 7 хоногт ажилладаг дундаж өдөр зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна. Боловсрол зайлшгүй эзэмисэн байх 7-15 наасны 194 хүүхдүүдийн 48.5 хувь нь сургууль завсардсан байгаа ба хүйсээр авч үзэхэд эрэгтэй хүүхдүүдийн сургууль завсардалт эмэгтэй хүүхдүүдийнхээс 13.2 пункттээр дээгүүр байна. Айлд мал мал лаж байгаа 7-15 наасны хүүхдүүдийн сургуульд хамрагдалт улсын дундажтай харьцуулахад маш доогуур, бичиг үсэггүй хүүхдүүдийн хувь, ялангуяа сургууль завсардсан хүүхдүүдийн дунд өндөр байна. Мал маллах ажил хий х болсон шалтгаан нь эрэгтэй хүүхдүүдийн хувьд өрхийн орлогого нэмэгдүүлэх, эцэг эх шаардсан, эц эг эх ажилгүй сургууль завсардсан гэсэн шалтгаанууд нэлээд тохиолдож байхад, охидуудын хувьд эцэг эх нь шаардсан, бусдад туслах, өрхийн орлого нэмэгдүүлэх, эцэг эх ажилгүй, сургууль завсардсан гэсэн шалтгаануудыг илүүтэйгээр дурьдсан байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн 64.3 хувь нь анх ажил хи тхдээ сургуулиас завсардаагүй байсан бол, 21.4 хувь нь завсардсан байсан, 14.3 хувь нь ажил хийхийн тулд сургууль завсардсан байв. 7-15 наасны хүүхдүүдийн дийлэнх нь сургуульд огт ороогүй буюу 1-4 ангиасаа сургууль завсардсан байна. Айлын эзэн, эзэгтэй зодох, айлан сурдүүлэх зэрэг хүчирхийлэлд өртөсөн хүүхдүүдийн сургууль завсардалт өндөр байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчшигүй хэлбэр айлд ажиллаж буй сургууль завсардсан хүүхдүүдийн хувьд бий болжээ гэж дүгнэхээр байна. Хүүхдүүдийн ихэнх нь 7 хоногт ба түүнээс дээш өдөр ажиллаж байгаа ба бүтэн 7 хоног амралтгүй ажилладаг хүүхдүүдийн сургууль завсардалт өндөр ба йна. Хүүхдүүд ихэвчлэн мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлсөө авдаг ба ажлын хөлс авдаггүй хүүхдүүд илүүтэй үгээр сургууль завсардажээ.*

### **1. Удиртгал**

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үсийн эдийн засгийн арга хэмжээнүүд, түүнчлэн нийгмийн салбарт бий болсон хүндэрэл бэрхшээлийн улмаас 1990-ээд оны эхээр сургууль завсардалт урьд байгаагүй түвшинд хүртэл нэмэгдэж, хүн амын нэлээд хэсэг нь ядуурч, сургууль завсардсан хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь бодит үзэгдэл болсоор 10 гаруй жил болж байна.

Бүрэн бус дунд боловсролыг бүх нийтээрээ албан ёсоор эзэмших ёстой хэдий ч улсын хэмжээнд 2000 оны эхний байдлаар 8-15 наасны 68.2 мянган хүүхэд сургуульд

суралцаагүй байсны 42.1 мянга буюу 61.7 хувь нь хөвгүүд, 26.1 мянга буюу 38.3 хувь нь охид байв.

Сүүлийн жилүүдэд бага болон суурь боловсролын гадна байгаа хүүхдүүдийн тоо буурч байгаа боловч, 2004-2005 оны хичээлийн жилийн байдлаар 10770 хүүхэд сургууль завсардсан нь бага биш тоо юм.<sup>11</sup>

2004 оны байдлаар 10-14 насны хүүхдийн 10.5 хувь боловсролын үйлчилгээнд огт хамрагдаагүй, 15-17 насны хүүхдийн 8.8 хувь нь огт боловсрол эзэмшигэй, 9.2 хувь нь бага боловсрол ч эзэмшигэй байна.<sup>12</sup>

Ийнхүү өнөөдрийн тулгамдсан асуудал болж байгаа сургууль завсардалт нь хүүхдийн сурах, хөгжих, улмаар нийгмийн бүтээлч иргэн болж төлөвшихөд садаа учруулж, хүүхдийн үндсэн эрхийг зөрчиж буй үзэгдэл юм. Сургууль завсардсан хүүхдүүд хөдөлмөрийн харилцаанд эрт орж, насандаа тохирохгүй, эсвэл эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хөдөлмөр эрхлэх эрсдэл нь нэмэгддэг бөгөөд энэ нь эргээд ядуурлыг цаашид улам гүнзгийрүүлэх нөхцөл болдог сөрөг үр дагавартай юм.

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн эрэгтэй хүүхдүүдийг, хөдөө аж ахуйн бус үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн эрэгтэй хүүхэдтэй харьцуулахад сургуулиас завсардах нь 2 дахин илүү байна.<sup>13</sup>

Манай улс нь цөөн хүн амтай, эдийн засаг нь шилжилтийн үедээ явж буй хөгжиж буй орон учраас хойч ирээдүй болсон хүүхдүүдийн сургууль завсардалт нь хүүхдүүдийн амьдралын хэв маяг, орчин нөхцөлтэй тодорхой хамаарал байгаа эсэхийг тодруулан бүсчилсэн бодлого явуулах, хүүхдүүдийн сургууль завсардалтыг ойрын хугацаанд болон алс ирээдүйд зохицуулах үйл ажиллагааг тодруулах шаардлага мөн л гарч байна. Эдгээр төсөөлөл болон нийгмийн хөгжлийн өнөөгийн явцад илрэч буй хүүхдүүдийн сургууль завсардалттай, ялангуяа мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалттай холбогдсон бодит үзэгдлийг судалж, сөрөг зохисгүйг аль болохоор арилгах арга механизмын талаар үндэслэлтэй санал, арга хэмжээ боловсруулахад шинэчлэлт хийх шаардлагатай байна. Судалгааны ажлын дүн бодлого боловсруулагчид, сургууль завсардалтад нөлөөлөх хүчин зүйлүүдийн төлөв байдлыг тодорхойлохыг хүссэн судлаачдад зохих ач холбогдлоо өгнө хэмээн найдаж байна.

### *Судалгааны зорилго*

Хөдөөд айлд мал маллаж, гэрийн ажил хийж буй 7-15 насны хүүхдүүдийн сургууль завсардалтын байдлыг гүнзгийрүүлэн судалж, сургууль завсардалтын шалтгааныг нь хүн ам зүй, нийгэм-өрх, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй хамааруулж, уялдаа холбоог тодорхойлох явдал энэхүү ажлыг үндсэн зорилго байв.

### *Судалгааны шинэлэг байдал*

Хүүхдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийн талаар хийгдсэн судалгааны ажлууд олонтоо тохиолддог. Гэвч манай нийгэмд тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байгаа сургууль завсардалт ялангуяа хөдөө айлд мал маллах ажил хийж байгаа

<sup>11</sup> ҮСГ, 2005. Боловсролын статистикийн мэдээ, УБ

<sup>12</sup> ҮСГ, 2004. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа 2002-2003, УБ

<sup>13</sup> ҮСГ, 1998. Хүн амын амьжиргааны түвшний судалгаа-1998, УБ

хүүхдүүдийн сургууль завсардалтын асуудлыг судалгааныхаа гол объект болгон, тэдгээрийн уялдаа холбоо, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар нарийвчлан хийсэн судалгааны ажил төдийлөн хийгдээгүй байна.

Түүнчлэн хөдөө айлд мал маллаж буй хүүхдүүдийн сургууль завсардалтанд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгааг хийснээр суурь боловсрол эзэмшигч хүүхдүүдийн нийтлэг дүр төрхийг тодорхой хэмжээгээр харуулж чадна гэж үзсэн болно.

## 2. Арга зүй, аргачлал

### Мэдээллийн эх үүсвэр


Энэхүү ажлаараа 2004 онд МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс явуулсан □Гэрийн үйлчлэгч хүүхдийн суурь судалгаа□-ны □Айлд мал малладаг хүүхдийн судалгаа□ гэсэн хэсгийн мэдээллийг ашиглан шинжилгээ хийв.

ХАССТ-ийн хийсэн дээрх судалгааны түүвэрлэлтэнд Ховд, Хөвсгөл,Өвөрхангай гэсэн 3 аймгийн айлд мал малладаг, гэрийн ажил хийдэг 6-17 настны нийт 270 хүүхэд хамрагдсан юм. Харин энэхүү ажлынхаа гүнзгийрүүлсэн шинжилгээнд Монгол улсын бага дунд боловсролын тухай хуулинд өрөнхий боловсролын сургуульд 7 настай хүүхдийг элсүүлнэ<sup>14</sup> гэж заасныг үндэс болгон суурь боловсрол зайлшгүй эзэмших ёстой 7-15 настны нийт 194 хүүхдүүдийг сонгож авав.

### Шинжилгээний хүрээ

Шинжилгээнд айлд мал маллаж буй хүүхдүүдийн сургууль завсардсан эсэх гэсэн хамаарах хувьсагчийг авч үзлээ. Ул хамаарах хувьсагчдыг хүн ам зүй, нийгэм-өрхийн, эдийн засгийн хүчин зүйлс гэсэн 3 бүлэгт ангилан, дараах хувьсагчуудаас хамааруулан шалтгааны загвараар шинжилгээг хийлээ. Уг загварыг схемчилэн харуулбал:

#### Зураг 1. Айлд мал малладаг 7-15 настны хүүхдүүдийн сургууль завсардалтын шалтгааны загвар



<sup>14</sup> Бага дунд боловсролын тухай хууль, Бүлэг 12-ийн 4-р зүйл

## ***Ойлголт, тодорхойлолтууд***

**Мал маллаж буй хүүхэд:** Айлд мал маллах ажлыг хийж, гэр орных нь ажилд тус нэмэр болж байгаа 7-15 насны хүүхдүүдийг хамруулав.

**Сургууль завсардсан хүүхэд:** Боловсролын зэрэг олгох сургуульд суралцаагүй боловч өмнө нь боловсролын тогтолцооны аль нэг түвшинд суралцаж байгаад, түвшнээ бүрэн дүүргээгүй 7-15 насны хүүхдүүд.

**Хүн ам зүйн хүчин зүйл:** Нас, хүйс, анх ажил хийж эхэлсэн нас гэсэн үзүүлэлтээр илэрхийлнэ.

**Нийгэм, өрхийн хүчин зүйл:** 1/ Эцэг, эхийн боловсролын түвшин, 2/ Эцэг, эхийн ажил эрхлэлт, 3/ Өрхийн ам бүлийн тоо, 4/ Хүчирхийлэлд өртөлт (эзэгтэй зодох, бэлгийн хүчирхийлэл, хэл амаар доромжлох, айлан сүрдүүлэх, бага хоол эсвэл хоол огт өгөхгүй байх, бага хөлс төлөх, хөлс/төлбөр огт төлдөггүй гэсэн 7 багц үзүүлэлтээс тооцсон), 5/ Бичиг үсэг мэдэлтийн түвшин, 6/ Буруу зурсилгтай байдал (тамхи татдаг байдал, согтууруулах ундааны зүйл хэрэглэж үзсэн эсэх, мансууруулах бодис хэрэглэх гэж оролдож байсан эсэх)

**Эдийн засгийн хүчин зүйл:** 1/ Өрхийн үндсэн хөрөнгө (тухайн өрхийн үндсэн хөрөнгийг 2004 онд Үндэсний Статистикийн Газраас гаргасан жилийн белютень, танилцуулгаар гаргасан улсын дундаж үнээр малыг нь үнэлэн авч үзсэн. Тэмээ □ 156500 төгрөг, Адуу □ 92500 төгрөг, Yхэр□71500 төгрөг, Хонь□3500 төгрөг, Ямаа-21500 төгрөг), 2/ 7 хоногт ажилладаг дундаж хугацаа.

### ***Статистик шинжилгээ***

Айлд мал малладаг сургууль завсардсан ба завсардаагүй хүүхдүүдийн шинж байдлын ялгааг тархалтын давтамж болон хамаарлын хүснэгт ашиглан гаргав. Хамаарах болон үл хамаарах хувьсагчдын хоёр хүчин зүйлийн хамаарлыг  $\chi^2$ -тестийг ашиглан шалгав. Сургууль завсардалтын байдал гэсэн хамаарах хувьсагч нь тийм, үгүй гэсэн хоёр сонголттой хувьсагч бөгөөд сургууль завсардалтанд нөлөөлөгч олон хүчин зүйлийн шинжилгээг ложистик регрессийн загварыг ашиглан үнэлсэн. Үүний үндсэн дээр хүн ам зүйн хүчин зүйлийн (загварA) сургууль завсардалт дахь нөлөөлөл, хүн ам зүй ба нийгэм-өрхийн хүчин зүйлийн (загварB) сургууль завсардалт дахь нөлөөлөл, хүн ам зүй, нийгэм-өрх болон эдийн засгийн хүчин зүйлийн (ЗагварC) сургууль завсардалт дахь нөлөөллийг тодорхойлогч загваруудыг гаргасан.

### ***3. Айлд мал маллаж буй хүүхдүүдийн сургууль завсардалтад нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ***

Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн хувьд сургууль завсардалтанд нөлөөлөгч гэж үзэж буй хүчин зүйлүүд нь сургууль завсардалтын байдал буюу бидний авч үзэж байгаагаар таамаглагдаж буй хүчин зүйлтэй ямар хамааралтай байна вэ гэсэн асуултанд хариулт өгөх зорилгоор хоёр хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг хийсэн болно.

1. Тэг таамаглал :

$H_0 = X$ үн ам зүй, нийгэм-өрх, эдийн засгийн хүчин зүйлүүд нь сургууль завсардалтын байдалтай хамааралгүй.

2. Өрсөлдөгч таамаглал:

$H_1$  = Хүүхдийн нас, хүйс, анх ажил хийж эхэлсэн нас нь сургууль завсардалттай хамааралтай.

$H_2$  = Эцэг, эхийн боловсрол, эцэг, эхийн ажил эрхлэлт, өрхийн ам бүлийн тоо, хүчирхийлэлд өртөлт нь сургууль завсардалттай хамааралтай.

$H_3$  = Өрхийн үндсэн хөрөнгө, 7 хоногт ажилладаг дундаж өдөр гэсэн үзүүлэлтүүд нь хүүхдийн сургууль завсардалттай хамааралтай.

3. Статистик шалгуур: Сургууль завсардалт ба түүнд нөллөөлийн гэж авч үзэж байгаа хувьсагчуудын хоорондын хамаарлыг хамгийн их үнэний хувь бүхий аргад үндэслэх  $\chi^2$  шалгуураар үнэлэв.

4. Итгэх түвшинг  $\alpha = 0.05$  буюу үнэлгээний алдааг хамгийн ихдээ 95 хувь байхаар тооцсон.

5. Түүвэр олонлогийн тархалтыг  $(r-1)(c-1)$  гэсэн чөлөөний зэрэг бүхий  $\chi^2$  тархалтаар тархаана гэж үзнэ.

6. Шалгуур мужийг чөлөөний зэрэг (df) болон итгэх түвшинг ашиглан үнэлсэн утгаа хүснэгтийн онолын утгатай харьцуулан үнэлсэн.

### ***Xүн ам зүйн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хамаарал***

Хүснэгт 1-д судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүн ам зүйн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хоорондох хамаарлыг авч үзлээ.

Хүн ам зүйн хүчин зүйлээс хүүхдийн нас, хүйс нь сургууль завсардалттай хамааралгүй, харин анх ажил хийж эхэлсэн нас сургууль завсардалттай хамааралтай байв.

7-11 насны буюу бага ангийн хүүхдүүдийн 53.6 хувь, 12-15 насны буюу дунд ангийн хүүхдүүдийн 46.4 хувь нь сургууль завсардсан байв. Эрэгтэй хүүхдүүдийн 53.2 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 40.0 хувь нь сургууль завсардсан байна. Айлд мал маллаж буй хүүхдийн нас, хүйс зэрэг нь сургууль завсардалтын байдалтай статистик ач холбогдлын түвшинд хамааралгүй өөрөөр хэлбэл хүүхдийн нас ба сургууль завсардалт, хүүхдийн хүйс ба сургууль завсардалтын хооронд статистик ач холбогдол оршихгүй байна.

Харин мал малладаг хүүхдүүд анх сургуульд орохосоо өмнө буюу 5-6 насандаа, дунд ангид буюу 12-15 насандаа ажил хийсэн хүүхдүүд илүүтэйгээр сургууль завсардсан байна. Энэ нь анх ажил хийж эхэлсэн нас нь сургууль завсардалттай статистик ач холбогдлын түвшинд хамааралтай байв ( $p=0.003$ ).

*Хүснэгт 1. Хүн ам зүйн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хоорондын хамаарал, хүйсээр*

| Хүн ам зүйн хүчин зүйл           | Сургууль завсардалт |            |
|----------------------------------|---------------------|------------|
|                                  | Бүгдэд эзлэх хувь   | Бүгд       |
| <b>Нас</b>                       |                     |            |
| 7-11                             | 53.6                | 56         |
| 12-15                            | 43.4                | 138        |
| $\chi^2 = 0.826$                 |                     |            |
| Df = 1                           |                     |            |
| P = 0.364                        |                     |            |
| <b>Хүйс</b>                      |                     |            |
| Эрэгтэй                          | 53.2                | 124        |
| Эмэгтэй                          | 40.0                | 70         |
| $\chi^2 = 3.134$                 |                     |            |
| Df = 1                           |                     |            |
| P = 0.077                        |                     |            |
| <b>Анх ажил хийж эхэлсэн нас</b> |                     |            |
| 5-6                              | 68.3                | 41         |
| 7-11                             | 39.0                | 118        |
| 12-15                            | 57.1                | 35         |
| $\chi^2 = 11.757$                |                     |            |
| Df = 2                           |                     |            |
| P = 0.003                        |                     |            |
| <b>Бүгд</b>                      | <b>48.5</b>         | <b>194</b> |

*Тайлбар:*  $\chi^2$  □ ач холбогдлын түвшин: итгэмжлэх түвшин нь  $\alpha = 95$  хувь

*Нийгэм, өрхийн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хамаарал*

Хүснэгт 2-т судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нийгэм-өрхийн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хоорондох хамаарлыг авч үзлээ.

Боловсролгүй буюу бага боловсролтой гэж хариулсан эцэг, эхтэй хүүхдүүдийн талаас илүү нь сургууль завсардсан байгаа нь эцэг эхийн боловсролын түвшин нь хүүхдийн сургууль завсардалтанд хүчтэй нөлөө үзүүлж байна (харгалзан p=0.001 ба p=0.000 ).

Аав нь ажилтай айлын хүүхдүүд илүү сургууль завсардсан байгаа нь аав нь мал маллах ба хувиараа хөдөлмөр эрхлэх ажилдаа хүүхдүүдээ ихээр туслалцуулдаг байж магадгүй гэж хэлж болох талтай юм.

*Хүснэгт 2. Нийгэм, өрхийн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хоорондын хамаарал, хүйсээр*

| Нийгэм, өрхийн хүчин зүйл  | Сургууль завсардалт |      |
|----------------------------|---------------------|------|
|                            | Бүгдэд эзлэх хувь   | Бүгд |
| <b>Эцгийн боловсрол</b>    |                     |      |
| Боловсролгүй ба бага       | 63.3                | 60   |
| Бүрэн бус дунд             | 42.4                | 59   |
| Бүрэн дунд ба түүнээс дээш | 23.3                | 30   |
| $\chi^2 = 13.679$          |                     |      |
| Df = 2                     |                     |      |
| P = 0.001                  |                     |      |

|                                   |             |            |  |
|-----------------------------------|-------------|------------|--|
| <b>Эхийн боловсрол</b>            |             |            |  |
| Боловсролгүй ба бага              | 66.7        | 57         |  |
| Бүрэн бус дунд                    | 50.0        | 60         |  |
| Бүрэн дунд ба түүнээс дээш        | 22.6        | 53         |  |
| $\chi^2 = 21.688$                 |             |            |  |
| Df= 2                             |             |            |  |
| P= 0.000                          |             |            |  |
| <b>Эцгийн ажил эрхлэлт</b>        |             |            |  |
| Ажилтай                           | 50.4        | 121        |  |
| Ажилгүй                           | 33.3        | 24         |  |
| Эдийн засгийн идэвхигүй           | 25.0        | 4          |  |
| $\chi^2 = 3.143$                  |             |            |  |
| Df= 2                             |             |            |  |
| P= 0.208                          |             |            |  |
| <b>Эхийн ажил эрхлэлт</b>         |             |            |  |
| Ажилтай                           | 43.2        | 95         |  |
| Ажилгүй                           | 23.1        | 26         |  |
| Эдийн засгийн идэвхигүй           | 67.3        | 49         |  |
| $\chi^2 = 14.675$                 |             |            |  |
| Df= 2                             |             |            |  |
| P= 0.001                          |             |            |  |
| <b>Өрхийн ам бүлийн тоо</b>       |             |            |  |
| 1-3                               | 67.6        | 34         |  |
| 4-6                               | 41.8        | 110        |  |
| 7+                                | 50.0        | 50         |  |
| $\chi^2 = 7.002$                  |             |            |  |
| Df= 2                             |             |            |  |
| P= 0.030                          |             |            |  |
| <b>Хүчирхийлэлд өртсөн байдал</b> |             |            |  |
| Өртсөн                            | 63.9        | 83         |  |
| Өртөөгүй                          | 36.9        | 111        |  |
| $\chi^2 = 13.778$                 |             |            |  |
| Df= 1                             |             |            |  |
| P= 0.000                          |             |            |  |
| <b>Бүгд</b>                       | <b>48.5</b> | <b>194</b> |  |

*Tайлбар:*  $\chi^2$  □ ач холбогдын түвшин: итгэмжлэх түвшин нь  $\alpha = 95\%$

Харин ээж нь эдийн засгийн идэвхигүй буюу 1-3 ам бүлтэй айлын хүүхдүүдийн талаас илүү хувь нь сургууль завсардсан байгаа нь мал маллах ажил нь нэлээд хүч хөдөлмөр шаардсан ажил тул ажиллах хүч хүрэлцдэггүйгээс цөөхөн ам бүлтэй айлын хүүхдүүд илүү сургуулиас гардаг байж болох талтай. Мөн 7 ба түүнээс дээш ам бүлтэй айлын хүүхдүүд олон ам бүлтэй учир орлого бага улмаас сургууль завсардсан байж болох талтай. Харин хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн 63.9 хувь .өртөөгүй хүүхдүүдийн 36.9 хувь нь сургууль завсарджээ. Хүчирхийлэлд өртсөн байдал, эхийнх нь ажил эрхлэлт, өрхийн ам бүлийн тоо зэрэг нь сургууль завсардалтанд хүчтэй нөлөөг үзүүлж байна (харгалзан  $p=0.000$  ба  $p=0.001$  ба  $p=0.030$ ). Эцгийн ажил эрхлэлт нь сургууль завсардалтын байдалтай огт хамааралгүй, эдгээр үзүүлэлтүүдийн хооронд статистик ач холбогдол оршихгүй байна.

## **Эдийн засгийн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хамаарал**

Хүснэгт 3-т судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эдийн засгийн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хамааралыг авч үзлээ.

### **Хүснэгт 3. Эдийн засгийн хүчин зүйлс ба сургууль завсардалтын хоорондын хамаарал, хүйсээр**

| Эдийн засгийн хүчин зүйл              | Сургууль завсардалт |            |
|---------------------------------------|---------------------|------------|
|                                       | Бүгдэд эзлэх хувь   | Бүгд       |
| <b>Малын өргөг / сая.төг /</b>        |                     |            |
| 2,000,0 хүртлэх                       | 43.2                | 37         |
| 2,000,0-4,000,0                       | 74.1                | 27         |
| 4,001.0-8,000.0                       | 41.5                | 41         |
| 8,001,0 ба дээш                       | 50.                 | 34         |
| Малгүй                                | 43.6                | 55         |
| $\chi^2 = 8.844$                      |                     |            |
| Df= 4                                 |                     |            |
| P=0.065                               |                     |            |
| <b>7 хоногт ажилладаг дундаж өдөр</b> |                     |            |
| 1-2                                   | 5.6                 | 18         |
| 3-5                                   | 30.4                | 23         |
| 6                                     | 50.0                | 2          |
| 7                                     | 56.3                | 151        |
| $\chi^2 = 19.968$                     | 19.968              |            |
| Df= 3                                 | 3                   |            |
| P= 0.000                              | 0.000               |            |
| <b>Бүгд</b>                           | <b>48.5</b>         | <b>194</b> |

**Тайлбар:**  $\chi^2$  □ ач холбогдлын түвшин: итгэмжлэх түвшин нь  $\alpha = 95\%$

Малыг нь мөнгөн дунд шилжүүлснээр авч үзвэл, 4 сая төгрөгний үндсэн хөрөнгөтэй буюу малтай айлын хүүхдүүд нь илүү сургууль завсарджээ. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сургууль завсардалт, эдийн засгийн хүчин зүйлүүдийн хооронд статистикийн хамаарал бараг оршихгүй байгаа үр дүн гарав. Хүүхдүүдийн 7 хоногт ажилладаг дундаж өдөр сургууль завсардалтанд маш хүчтэй нөлөө үзүүлж байна ( $p= 0.000$ ).

Харин үндсэн хөрөнгийн хэмжээ нь сургууль завсардалтын байдалтай статистик хамааралгүй, энэ 2 үзүүлэлтүүдийн хооронд статистик ач холбогдол оршихгүй байна.

### **Олон хүчин зүйлийн шинжилгээ**

Өмнө авч үзсэн Хүн ам зүйн, Нийгэм-өрхийн болон Эдийн засгийн хүчин зүйлүүд нь сургууль завсардалтын байдалтай зарим нь хамааралтай нь тогтоогдсон билээ. Тэгвэл эдгээр хувьсагчуудын хамаарлын зүй тогтол чухам ямар хуулиар явагдаж байна вэ, өөрөөр хэлбэл сургууль завсардалтын байдалд хүн ам зүйн болон нийгэм ,өрх, эдийн засгийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байна вэ гэдгийг ложистик регрессийн шинжилгээгээр шалгав.

Энд үл хамаарах хувьсагчид нэрэлсэн түвшний хэмжигдэхүүн, хамаарах хувьсагч нь сургууль завсардсан, сургууль завсардаагүй гэсэн Dummy (тийм, үгүй гэсэн сонголттой ) хувьсагч юм.

Хүснэгт 4-д ложистик регрессийн шинжилгээний статистик ач холбогдлын түвшин, логарифмын харьцааг харуулав. Логарифмын харьцаа нь сургууль завсардах магадлалыг хүн ам зүй, нийгэм өрх, болон эдийн засгийн сонгосон үзүүлэлтүүдээр харуулж байгаа юм.

**Загвар А:** Хүн ам зүйн хүчин зүйлс ба мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтын хоорондын хамаарлын загвар

**Загвар В:** Хүн ам зүй, нийгэм , өрхийн хүчин зүйлс ба мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтын хоорондын хамаарлын загвар

**Загвар С:** Хүн ам зүй,нийгэм,өрх, болон эдийн засгийн хүчин зүйлс ба мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтын хоорондын хамаарлын загвар

Загварт үл хамаарах бүх хувьсагчдыг нэмэхэд бүх загваруудын үнэний хувийн харьцаа  $\chi^2$  утга буурсан бөгөөд бүгд өндөр ( $p=0.000$ ) хамааралтай байна. Энэ нь сургууль завсардалтын үнэлэгдсэн утгын статистик ач холбогдлын түвшин нэмэгдсэн гэдгийг харуулж байна. Үл хамаарах хувьсагч тус бүрийн хамаарах хувьсагчид үзүүлэх нөлөөг тооцоходо тухайн үл хамаарах хувьсагийн бүлэгт байгаа бүх үзүүлэлтийг тухайн бүлэг дэх сонгосон суурь нэг үзүүлэлтэд харьцуулсан логарифмийн харьцаагаар (энэ тохиолдолд суурь бүлгийн логарифмын харьцаа 1-тэй тэнцүү) тодорхойлов. Энэхүү харьцаа нь сонгосон загварт багтах бусад бүх үл хамаарах хувьсагчдын нөлөөллийг давхар авч үзэн тухайн үл хамаарах хувьсагчын бүлэг бүрт сургууль завсардсан хүүхдүүдийн талаарх магадлалыг суурь бүлэгтэй харьцуулсан харьцуулалт юм. Энэ харьцаа нэгээс бага байвал суурь бүлгийн магадлалаас бага харин нэгээс их байвал өндөр байгааг илэрхийлнэ.

Загвар А-ын хувьд хүн ам зүйн хүчин зүйлүүд болох хүүхдүүдийн нас, хүйс, анх ажил хийж эхэлсэн нас нь статистикийн ач холбогдол бүхий түвшинд хамааралгүй байна.

Загвар А□г өргөтгөөд нийгэм-өрхийн хүчин зүйлсийн сонгосон хувьсагчдыг нэмэхэд (Загвар В) хүүхдийн нас, хүйс, анх ажил хийж эхэлсэн насны үзүүлэлтүүд нь мөн л хамааралгүй байсан ба эхийн ажил эрхлэлт, эхийн боловсрол, хүчирхийлэлд өртсөн байдал зэрэг нь статистикийн ач холбогдлын түвшинд хамааралтай, бусад хувьсагчид статистик хамааралгүй байлаа.

Ээж нь бүрэн бус дунд боловсролтой хүүхдүүдийн сургууль завсардах магадлал нь ээж нь боловсролгүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 19 хувиар бага ( $p=0.021$ ) байгаа бол ээж нь бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой хүүхдүүдийн сургууль завсардах магадлал ээж нь боловсролгүй ба бага боловсролтой хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 25 хувиар бага ( $p=0.031$ ) байна. Энэ нь эхийн боловсролын түвшин дээшилэх тусам хүүхдүүдийн сургууль завсардалт буурч байгааг харуулж байна.

Ээж нь ажилгүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал ээж нь ажилтай хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 4 дахин өндөр ( $p=0.010$ ), харин ээж нь эдийн засгийн идэвхигүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал ээж нь ажилтай хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 11 дахин өндөр ( $p=0.002$ ) байгаа нь хүүхдийнх нь сургууль завсардалт ба эхийнх нь ажил эрхлэлтийн хоорондын эсрэг хамаарлыг харуулж байна.

Хүчирхийлэлд өртөөгүй буюу айлд мал маллах ажил хийхэд ямар ч бэрхшээл тохиолдоггүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал нь айлд мал маллах

ажил хийхэд бэрхшээл тохиолддог буюу хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 27 хувиар бага ( $p=0.002$ ) байна.

Сонгож авсан хүн ам зүйн үзүүлэлтүүдийн айлд мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтын байдлыг тайлбарлах чадвараас хүн ам зүйн, болон нийгэм-өрхийн үзүүлэлтүүдийн нь мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтыг тайлбарлах чадвар нь нэмэгджээ.

Сүүлийн загвар болох Загвар С-д эдийн засгийн хүчин зүйлс болон сонгож авсан хувьсагчидыг нэмэхэд эхийн ажил эрхлэлт, эхийн боловсролын түвшин, хүчирхийлэлд өртсөн байдал, 7 хоногт ажилладаг дундаж өдөр, өрхийн үндсэн хөрөнгө зэрэг нь хамааралтай байсан ба бусад бүх хувьсагчид статистикийн ач холбогдлын түвшинд хамааралгүй байв.

Ээж нь бүрэн бус дунд боловсролтой хүүхдүүдийн сургууль завсардах магадлал нь ээж нь боловсролгүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 11 хувиар бага ( $p=0.013$ ) байгаа бол ээж нь бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой хүүхдүүдийн сургууль завсардах магадлал ээж нь боловсролгүй ба бага боловсролтой хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 17 хувиар бага ( $p=0.028$ ) байна. Энэ нь эхийн боловсролын түвшин дээшилэх тусам хүүхдүүдийн сургууль завсардалт буурч байгааг харуулж байна.

Ээж нь ажилгүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал ээж нь ажилтай хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 8 дахин өндөр ( $p=0.003$ ), харин ээж нь эдийн засгийн идэвхигүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал ээж нь ажилтай хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 16 дахин өндөр ( $p=0.004$ ) байгаа нь хүүхдийнх нь сургууль завсардалт ба эхийнх нь ажил эрхлэлтийн хоорондын эерэг хамаарлыг харуулж байна.

**Хүснэгт 4. Мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтанд нөлөөлж буй хүчин зүйлийн ложистик регрессийн үр дүн, сонгосон үл хамаарах хувьсагчуудаар**

| Үл хамаарах хувьсагчид              | Загвар А               |                | Загвар В               |                | Загвар С               |                |
|-------------------------------------|------------------------|----------------|------------------------|----------------|------------------------|----------------|
|                                     | Логарифмын харьцаа (B) | Стандарт алдаа | Логарифмын харьцаа (B) | Стандарт алдаа | Логарифмын харьцаа (B) | Стандарт алдаа |
| <b>1. ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛ</b>    |                        |                |                        |                |                        |                |
| <b>Нас</b>                          | 1.562                  | 0.386          | 1.390                  | 0.558          | 1.738                  | 0.672          |
| <b>Хүйс</b>                         |                        |                |                        |                |                        |                |
| Эрэгтэй                             | 1.000                  | 1.000          | 1.000                  | 1.000          | 1.000                  | 1.000          |
| Эмэгтэй                             | 0.577                  | 0.309          | 0.899                  | 0.417          | 0.687                  | 0.505          |
| <b>Анх ажил хийж эхлсэн нас</b>     | 0.968                  | 0.070          | 0.977                  | 0.102          | 0.916                  | 0.123          |
| <b>2. НИЙГЭМ, ӨРХИЙН ХҮЧИН ЗҮЙЛ</b> |                        |                |                        |                |                        |                |
| <b>Эцгийн боловсрол</b>             |                        |                |                        |                |                        |                |
| Боловсролгүй ба бага                |                        | 1.000          |                        | 1.000          |                        | 1.000          |
| Бүрэн бус дунд                      |                        | 0.914          |                        | 0.791          |                        | 1.839          |
| Бүрэн дунд ба түүнээс дээш          |                        | 1.348          |                        | 0.729          |                        | 2.309          |
| <b>Эхийн боловсрол</b>              |                        |                |                        |                |                        |                |
| Боловсролгүй ба бага                |                        | 1.000          |                        | 1.000          |                        | 1.000          |
| Бүрэн бус дунд                      |                        | 0.186 *        |                        | 0.741          |                        | 0.112*         |

|  |            |       |            |            |
|--|------------|-------|------------|------------|
| Бүрэн дунд ба түүнээс дээш                               | 0.248 *    | 0.648 | 0.170*     | 0.808      |
| <b>Эцгийн ажил эрхлэлт</b>                               |            |       |            |            |
| Ажилтай  | 1.000      | 1.000 | 1.000      | 1.000      |
| Ажилгүй  | 0.181      | 1.325 | 0.407      | 1.637      |
| Эдийн засгийн идэвхигүй                                  | 0.130      | 1.471 | 0.357      | 1.753      |
| <b>Эхийн ажил эрхлэлт</b>                                |            |       |            |            |
| Ажилтай  | 1.000      | 1.000 | 1.000      | 1.000      |
| Ажилгүй  | 3.632 **   | 0.503 | 7.523**    | 0.670      |
| Эдийн засгийн идэвхигүй                                  | 11.260 **  | 0.775 | 16.082**   | 0.973      |
| <b>Өрхийн ам бүлийн тоо</b>                              | 0.924      | 0.116 | 0.941      | 0.139      |
| <b>Хүчирхийлэлд өртөлт</b>                               |            |       |            |            |
| Өртсөн   | 1.000      | 1.000 | 1.000      | 1.000      |
| Өртөөгүй   | 0.268 **   | 0.431 | 0.187***   | 0.517      |
| <b>3. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛ</b>                       |            |       |            |            |
| <b>Өрхийн үндсэн хөрөнгө<br/>(Малын өртөг, сая. тог)</b> |            |       |            |            |
| 2,000.0 хүртлэх  |            |       | 1.000      | 1.000      |
| 2,000.0-4,000.0  |            |       | 1.565      | 0.829      |
| 4,001.0-8,000.0  |            |       | 0.101*     | 1.023      |
| 8,001.0 ба дээш  |            |       | 0.571      | 0.804      |
| Малгүй   |            |       | 0.454      | 0.762      |
| <b>7 хоногт ажилладаг дундаж өдөр</b>                    |            |       | 0.326***   | 0.295      |
| <b>Constant</b>  | - 0.063    | 0.628 | 2.517      | 1.708      |
| <b>2LL χ<sup>2</sup></b>                                 | 264.220*** |       | 153.840*** | 117.911*** |

Тайлбар: \*\*\*p<0.001, \*\* p<0.01, \* p<0.05 ач холбогдолын түвшинд хамаарлын коэффициентийг тооцв.

Энэ нь эхийнх нь ажилгүй буюу эдийн засгийн идэвхигүй байх нь өрхийн нийгэм, эдийн засгийн статус доогуур байх буюу тухайн өрхийн сарын орлогын хэмжээ ба амьжиргааны түвшин нь доогуур байх ба ядууралд өртөх магадлалтай гэж тайлбарлаж болох юм. Мөн орлогын хэмжээ бага ядууралд өртсөн өрхийн эжүүдэд хүүхдээ сургуульд сургахад хэрэглэх хувцас хунар, хичээлийн хэрэглэлийг авах мөнгө хүрэлцдэггүй байж болох юм. Мэдээж дан ганц эхийнх нь ажил эрхлэлт тухайн өрхийн амьжиргааны түвшинийг тодорхойлож чадахгүй учир (энэхүү ажлын хязгаарлагдмал байдал гэж өмнө дурьдсан билээ) дараа дараагийн судалгаанд хүүхдүүдийн сургууль завсардалтанд өрхийн нийгэм, эдийн засгийн статус, ялангуяа өрхийн амьжиргааны түвшний үзүүллэлтүүд, сарын дундаж орлого, нэг хүнд ноогдох сарын хэрэглээний түвшин хэрхэн нөлөөлж байна вэ гэдгийг нарийн судлах хэрэгтэй юм.

4-8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй өрхийн хүүхдүүдийн сургууль завсардах магадлал 2 хүртлэх сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй өрхийн хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 10 хувиар бага ( $p=0.025$ ) байна.

Хүчирхийлэлд өртөөгүй буюу айлд мал маллах ажил хийхэд ямар ч бэрхшээл тохиолддоггүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал нь айлд мал маллах ажил хийхэд бэрхшээл тохиолддог буюу хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн сургууль завсардах магадлалаас 20 хувиар бага ( $p=0.001$ ) байна.

Хүүхдүүдийн 7 хоногт ажилладаг дундаж өдөр нь нэг өдрөөр багасгад хүүхдүүдийн сургууль завсардах магадлал 33 хувиар ( $p=0.000$ ) буурна.

#### **4. Дүгнэлт, зөвлөмж**

Энэхүү судалгааны ажлаар мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтанд тухайн хүүхдийн анх ажил хийж эхэлсэн нас, эхийн боловсрол, ажил эрхлэлт, хүчирхийлэлд өртөлт, өрхийн үндсэн хөрөнгө, 7 хоногт ажилладаг дундаж өдөр зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна гэдгийг олж тодорхойлов.

- Айлд мал малладаг суурь боловсрол зайлшгүй эзэмшийн байх 7-15 насын 194 хүүхдүүдийн 48.5 хувь нь сургууль завсардсан байгаа ба насын бүлгээр нь харахад 7-11 насын буюу бага ангийн 2 хүүхэд тутмын нэг нь, 12-15 насын буюу дунд ангийн хүүхдүүдийн 46.4 хувь нь сургууль завсардсан байна. Харин хүйсээр авч үзэхэд эрэгтэй хүүхдүүдийн сургууль завсардалт эмэгтэй хүүхдүүдийнхээс 13.2 пунктээр дээгүүр байна.
- Айлд мал маллаж байгаа 7-15 насын хүүхдүүдийн сургуульд хамрагдалт улсын дундажтай харьцуулахад маш доогуур, бичиг үсэггүй хүүхдүүдийн хувь, ялангуяа сургууль завсардсан хүүхдүүдийн дунд өндөр байна. Айлд мал маллаж буй бага ангийн буюу 7-11 насын, эрэгтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших эрх илүүтэйгээр хэрэгжихгүй байна.
- Мал маллах ажил хийх болсон шалтгаан нь эрэгтэй хүүхдүүдийн хувьд өрхийн орлогоо нэмэгдүүлэх, эцэг эх шаардсан, эцэг эх ажилгүй сургууль завсардсан гэсэн шалтгаанууд нэлээд тохиолдож байхад, охидуудын хувьд эцэг эх нь шаардсан, бусад туслах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, эцэг эх ажилгүй, сургууль завсардсан гэсэн шалтгаануудыг илүүтэйгээр дурьдсан байна.
- Сургууль завсардсан хүүхдүүдийн 64.3 хувь нь анх ажил хийхдээ сургуулиас завсардаагүй байсан бол, 21.4 хувь нь завсардсан байсан, 14.3 хувь нь ажил хийхийн тулд сургууль завсардсан байв.
- Сургууль завсардсан мал маллаж буй 7-15 насын хүүхдүүдийн дийлэнх нь сургуульд огт ороогүй буюу 1-4 антиасаа сургуулиас завсардсан байна.
- Сургууль завсардсан хүүхдүүдийн анх ажил хийж эхэлсэн дундаж нас 8.8 байв.
- Хамаатан бус айлд ажилладаг хүүхдүүд илүүтэйгээр сургууль завсардаж байна.
- Бүтэн өнчин хүүхдүүдийн гуравны нэг нь, хагас өнчин хүүхдүүдийн талаас илүү (68.0 хувь) нь сургууль завсарджээ.
- Айлд ажиллаж байгаа хүүхдүүдийн эцэг, эхийн боловсролын түвшин доогуур байгаа, тодруулбал эцэг, эх нь боловсролгүй ба бага боловсролтой хүүхдүүдийн талаас илүү хувь нь сургууль завсардаж байна.
- Аав нь ажилтай, ээж нь эдийн засгийн идэвхигүй өрхийн хүүхдүүд илүүтэйгээр сургууль завсардаж байна. Энэ нь эцэг, эхчүүд мал аж ахуйн ажлыг илүүтэй анхаарч, хүүхдийнхээ боловсролын асуудлыг орхигдуулж, боловсролыг үнэлэх, түүнд хандах хандлага доогуур байгааг илтгэж байна.
- Сургууль завсардсан айлд ажиллаж байгаа хүүхдүүд 4 ба түүнээс дээш гишүүнтэй олон ам бүлтэй өрхийн хүүхдүүд байгаа ба 1-3 ам бүлтэй өрхийн хүүхдүүдийн сургууль завсардалт өндөр байна.
- Айлын эзэн, эзэгтэй зодох, айлган сүрдүүлэх гэсэн төрлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн сургууль завсардалт өндөр байна.

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр айлд ажиллаж буй сургууль завсардсан хүүхдүүдийн хувьд бий болжээ гэж дүгнэхээр байна.
- Хүүхдүүдийн ихэнх нь 7 хоногт 6 ба түүнээс дээш өдөр ажиллаж байгаа ба бүтэн 7 хоног амралтгүй ажилладаг хүүхдүүдийн сургууль завсардалт өндөр байна.
  - Малыг нь зах зээлийн үнэд шилжүүлснээр малгүй болон 4 сая төгрөгнөөс дооши үндсэн хөрөнгөтэй айлын хүүхдүүдийн талаас илүү хувь нь сургууль завсардсан байна.
  - Сургууль завсардсан хүүхдүүдийн 44.7 хувь нь ХАА-н ажил/ малчин , 43.6 хувь нь ХАА-н бус ажил хийнэ гэсэн сонголтыг хийж байна.
  - Сургууль завсардсан ба завсардаагүй хүүхдүүдийн дунд мал маллах ажлаа цаашид үргэлжлүүлэн хийнэ гэсэн хувь бараг ойролцоо байна.
  - Сургууль завсардсан хүүхдүүд насанд хүрээгүй хүний ажил хийх насыны талаарх хуулийн мэдлэг болон сургуульд сурхээ тэр бүр мэддэггүй байна.
  - Хүүхдүүд ихэвчлэн мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлсөө авдаг ба ажлын хөлс авдаггүй хүүхдүүд илүүтэйгээр сургууль завсарджээ.
  - Сургууль завсардсан хүүхдүүдийн хүйсийн хувьд болон аль ч насыны хүүхдүүдийн хувьд ар гэрийн гачигдал, сурхээ сонирхолгүй гэсэн шалтгаанууд нь сургууль завсардах гол шалтгаан болж байна.
  - Мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтанд жендерийн ялгаа байхгүй гэсэн таамаглал батлагдаж, сургууль завсардалттай статистик ач холбогдол байхгүй байв.
  - Мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардалтын байдалд нөлөөлнө гэж таамагласан хүчин зүйлүүд болох эхийн боловсрол, эхийн ажил эрхлэлтийн байдал, 7 хоногт ажилладаг дундаж өдөр бүгд сургууль завсардалтын байдалтай статистик ач холбогдол бүхий хамааралтай байна.
  - Ээж нь бүрэн бус дунд ба түүнээс дээш боловсролтой, 4-8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй өрхийн, мал малладаг хүчирхийлэлд өртөөгүй хүүхдүүдийн сургууль завсардах магадлал хамгийн бага байна.
  - Харин ээж нь ажилгүй, болон эдийн засгийн идэвхигүй мал малладаг хүүхдүүдийн сургууль завсардах магадлал хамгийн өндөр байна.
  - 7 хоногт ажилладаг дундаж өдөр нэгээр багасхад хүүхдүүдийн сургууль завсардах магадлал буурч байна.

*Судалгааны үр дүнг үндэслэн дараах зөвлөмжүүдийг дэвишүүлж байна.*

*Засгийн газарт:*

- 7-15 хүртлэх насыны хүүхдүүдэд суурь боловсрол заавал эзэмшигүүлэх хуулийн хэрэгжилтийг хөдөө орон нутагт түүштэй нэн даруй эрчимжүүлэх, хяналтыг сайжруулах ба сургууль завсардсан хүүхдүүдэд зориулсан янз бүрийн сургалтын хэлбэрүүдийг малчин хүүхдүүдэд ойртуулах шаардлагатай байна.
- Эцэг, эхчүүдийн боловсролын талаарх ойлголтыг сайжруулах, тэдэнд мал маллах ажил нь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр гэдгийг ойлгуулах ухуулга сурталчилгааг зохион байгуулах
- Сургууль завсардаад удсан хүүхдүүдийг хөнгөвчилсөн хэлбэрийн сургалтанд хамруулан үйлдвэрлэл сургалтын хэлбэрээр мэргэжил

эзэмшигүүлэхэд боловсрол, мэргэжлийн сургалтын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх

Эцэг эхчүүдэд:

- Эцэг, эхчүүд хүүхдээ сургуульд сурах боломж нөхцөлөөр хангаж өгөх
- Хүүхдээ ерөнхий боловсролын сургуулиас завсардуулахгүй байх, завсардсан байгаа бол бичиг үсгийн болон боловсрол олгох албан, эчнээ, албан бус сургалтанд нэн даруй хамруулах

*Сургууль, багши наарт:*

- Сургууль, багши нарын ажлын үнэлгээ, сургалтын төлөвлөгөөнд мал маллаж буй хүүхдүүдийг сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх заалтуудыг оруулах
- Сургууль завсардсан хүүхдүүдэд чөлөөтэй сурах нөхцөлийг бүрэн хангаж өгөх

#### **Ашигласан материал**

1. Г. Батчимэг, □Зах зээлийн үсийн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал□ УБ, 2000
2. МУИС, ХАССТ, “Улаанбаатар хотын зах дээр хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн нөхцөл байдал ” судалгааны илтгэл, УБ, 2002
3. “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл-2003
4. МУИС,ХАССТ, ~Алт олборлогч хүүхдүүдийн ажлын нөхцөл байдал”, 2004
5. МУИС,ХАССТ, ~Хүчирхийлэл ба хууль” сэдэвт судалгаа, 1998
6. Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг судалсан судалгааны тайлан, 2000
7. Н. Түмэнбаяр, “Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомжийн байдалд хийсэн судалгааны тайлан, 2000 он
8. ОУХБ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай олон улсын хөдөлмөрийн 182-р конвенц ,190-р зөвлөмж
9. ОУХБ, Ажилд авах насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн 138-р дугаар конвенц , 146-р зөвлөмж
10. УСГ, □Жиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2002-2003~, Улаанбаатар хот, 2004, тайлан, 2000 он
11. УСГ, ~Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан 2002-2003”, УСГ, Улаанбаатар хот, 2004
12. УСГ, ~Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа”, 2003

13. Хүүхдийг ивээх сан, □Яагаад хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байна вэ?□ , УБ, 2001
14. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах нь, парламантын гишүүдэд зориулсан гарын авлага, ОУХБ/АЙПЕК, Улаанбаатар хот, 2002
15. Хүүхдийн төлөө үндэсний газар, ~Хүүхдийн хөдөлмөр ба таны бүрэн эрх~, Улаанбаатар, 2004
16. Ш.Галбадрах “Хогийн цэг дээрх хүүхдийн хөдөлмөр “